



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/353

Мөрөн сум

Сумын цол олгох бөхийн барилдаан
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2233, Их Монгол Улсын 818, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Хөвсгөл аймаг байгуулагдсаны 93 жилийн ой, Мөрөн хот үүсэн байгуулагдсаны 215 жилийн ойд зориулан Мөрөн сумын баяр наадмын хүчит 64 бөхийн барилдааныг 2024 оны 07 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсугай.

2.Бөхийн барилдаан зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангуулж, үр дүнтэй зохион байгуулахыг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр)-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ

